



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/323

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт, "Хүнсний тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 14 дүгээр зүйлийн 14.1.3, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.1, 10.6.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын 5/К, аймгийн Засаг даргын 2023 оны А/08 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн суманд 2023 оны 04 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулагдах Төв, Хангайн бүсийн аймгуудын хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын ажилчдын "Ур чадварын уралдаан"-д аймгийн тогооч нарыг зохион байгуулан оролцуулахыг аймгийн Тогооч нарын холбоо (Ч.Сарантуяа)-д даалгасугай.

2."Монгол үндэсний болон орон нутгийн онцлогтой хоол, ундааг сурталчлан таниулж, уламжлал ба инновацыг түгээн дэлгэрүүлэх" арга хэмжээнд оролцоход 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэгийг 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө арга хэмжээний зардлын 20 дахь заалт Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АВИУН-ЭРДЭНЭ